

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны 08 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар А/281, А170

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зөгийн аж ахуйд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн хөгжлийн бодлого зохицуулалтын газар /Д.Батмөнх/ -т үүрэг болгосугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЙД

З.МЭНДСАЙХАН

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

А.АРИУНЗАЯА

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд,
Хөдөлмөр нийгмийн хамгааллын Сайдын
хамтарсан 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн
А/281, А/170 дугаар тушаалын хавсралт

“ЗӨГИЙН АЖ АХУЙД МӨРДӨХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ДҮРЭМ”

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү дүрмээр зөгийн аж ахуй эрхэлж буй иргэний эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Зөгийн аж ахуйн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаа нь байнгын, тасралтгүй байх бөгөөд тэдгээрт тавигдах хэм хэмжээний шаардлагад нийцсэн байна.

Хоёр. Нэр томьёо

2.1.Дүрэмд тусгагдсан нэр томьёог дараахь байдлаар ойлгоно. Үүнд:

2.1.1.“хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”- хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт, техник, технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээ авах, эмчлэх, сувилах, нөхөн сэргээх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаа;

2.1.2.“зөгийн аж ахуй”-зөгийг үржүүлэн, төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болон үйлчилгээ үзүүлдэг хөдөө аж ахуйн салбар;

2.1.3.”зөгийчин”-зөгийг арчилж маллан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлэх чадавхи бүхий мэргэжлийн хүн.

2.2.Уг дүрмийн 2.1-д тусгагдаагүй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой нэр томьёог Хөдөлмөрийн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн, Галын аюулгүй байдлын тухай болон холбогдох хууль тогтоомжид зааснаар зөгийн аж ахуйн холбогдолтой нэр томьёог MNS6827:2020, MNS6829:2020, MNS1551:1983, MNS6294:2011 стандартуудад тусгагдсан утгаар хэрэглэнэ.

Гурав. Үйлдвэрлэлд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага

Үйлдвэрлэл нь /агаар, хөрс, ус/ зэрэг хүрээлэн буй орчныг бохирдуулахгүй, хортой бодисын агууламж заасан хэмжээнээс хэтрэхгүй нөхцөлд явагдана.

3.1. Зөгийчинд тавигдах аюулгүй ажиллагааны заавар

3.1.1.Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/36 тоот тушаалаар баталсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ын 3.1.5 дахь заалтыг баримтлан 18 нас хүрсэн хүнийг ажиллуулна.

3.1.2.MNS 4970:2000 стандартын дагуу эмэгтэй зөгийчний гараар нэг удаа өргөх, зөөх ачааны дээд хэмжээ 20 кг, нэг дугуйтай түрдэг тэргэнцэрээр 50 кг, хоёр дугуйтай тэргэнцэрээр тэгш газарт 115 кг, тэгш бус газарт 60 кг, 3 ба 4 дугуйтай тэргэнцэрээр 100 кг байна.

3.1.3.Зөгийчин ажил эхлэхийн өмнө хамгаалах хэрэгслийг бүрэн, зөв өмсч, шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шалгах ба ажил дууссаны дараа

тэдгээрийг зориулалтын байранд эмх цэгцтэй хураана. Зөгийн үүрнээс холдсоны дараа хамгаалах хэрэгслийг тайлан, тусгай өлгүүрт хадгална.

3.1.4.Зөгийчний өмдний шуумаг нь доош тонгойход шагай давж байх хэмжээтэй байна. Ажлын хувцасны цоорхой болон хөлс, дизель түлшний хурц үнэрийг тогтмол шалгаж, цэвэрлэсэн байна. Үсийг малгайнаас ил гаргаж болохгүй.

3.1.5.Харшлын үед ашиглах анти-гистамины түрхлэг, бэлдмэл бүхий эмнэлгийн анхан шатны тусламжийн хайрцаг, байгаль, цаг агаарын хүчин зүйл, зэрлэг амьтны дайралт, галын аюул зэрэг болзошгүй хүчин зүйлийн үед хэрэглэх гар утсыг биедээ авч явна.

3.1.6.Зөгийчин нь багаж хэрэгсэлтэй зөв харьцан, бие махбодийн ачаалал, эрүүл мэндийн онцлогтоо тохируулан физик, хими, биологийн болзошгүй хүчин зүйлээс урьдчилан сэргийлж, өглөө эрт, үдээс өмнө зөгий нислэгт гарсан үеэр ажиллах зэргээр ажил, амралтыг зохистой зохицуулна.

3.1.7.Зөгийчинд галаас үүдэлтэй тууралт, загатнах, хавдах, бие сулрах, амьсгал давчдах, зүрх дэлсэх зэрэг харшлын шинж илэрвэл эрүүл мэндийн байгууллагад яаралтай хандана. Зөгийнд хатгуулсан тохиолдолд хатгуурыг чимхэж авч болохгүй, түүнийг хажуу тийш маажиж авна.

3.1.8.Нислэг дууссаны дараа болон бороотой, манантай, хэт халуун өдөр зөгийнд үзлэг хийхийг хориглоно. Үзлэгийн явцад механик гэмтэл авах, хатгуулахаас сэргийлж, хамгаалалтын бээлийг тогтмол хэрэглэнэ. Зөгийн авгалдай, үрвэлдэйг удаан хугацаагаар харж, нүд ядрахаас урьдчилан сэргийлнэ.

3.1.9.Утуурыг ашиглах явцад цогтой утаа үлээлгэх, түлэх, түлэгдэхээс болгоомжилж, хорт утаа гаргах материал ашиглахгүй, хордох, харшилтай болохоос хамгаална.

3.1.10.Зөгийн бүлийг өргөж зөөхийн өмнө замын саадыг зайлуулсан байна.

3.1.11.Бал ялгуурыг зөгийн сууриас зайдуу, тусгайлж тоноглогсон байранд байрлуулна. Бал ялгах явцад гар хуруу гэмтэхээс сэргийлнэ.

3.2. Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага

3.2.1.Зөгийн өвөлжөө нь уг дүрмийн 3.1.1-д, зөгийн гэр нь MNS6829:2020 стандартад заасан техникийн шаардлагад нийцсэн байна.

3.2.2.Зөгийнд үзлэг хийх, бал хураах, лав боловсруулах, эх зөгий гаргахад шаардагдах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглана.

3.2.3.Зөгийн гэрийг галын дөл, UV гэрлээр ариутгахдаа галын аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах ба багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг “Зөгийн аж ахуйд мал эмнэлгийн үйлчилгээ, эрүүл ахуйн шаардлагыг мөрдөх нийтлэг заавар”-ын дагуу ариутгана.

3.2.4.Зөгий тайвшруулах утуурыг гал авалцах материалаас 3 метрээс ойргүй зайнд саван дотор хадгална.

3.3. Зөгийн тээвэрлэлтэд тавигдах шаардлага

3.3.1.Зөгийг нислэгийн дараа үдэш, шөнийн цагаар тээвэрлэнэ. Сэрүүн, үүлэрхэг, бага зэргийн бороотой үед зөгийг үүрэндээ бүрэн орсон нөхцөлд өдрийн цагаар тээвэрлэнэ.

3.3.2.Зөгийг тээвэрлэхийн өмнө үүрний жинг хөнгөрүүлсэн байна.

3.3.3.Зөгийн үүрний жаазыг нэг тал руу нь шахаж, тусгай бэхлэгч, хадаасаар хөдөлгөөнгүй бэхэлнэ. Салхивчны торон хаалтыг нээж, гэрийг баглаж бооно. Гэрийн нисгэвчийг хаана.

3.3.4.Зөгийн хүнд жинтэй бүлийг доор нь байрлуулж, тээврийн хэрэгслийн тэвшнээс дээш 2 м-ээс өндөргүй байхаар зөгийн үүрний нисгэвчийг хойш нь харуулж байрлуулан, давхарлан ачиж, татлагаар бэхэлнэ.

3.3.5. Зөгийг тээвэрлэх явцад хүн ам олонтой газар зогсохоос зайлсхийж, 6 цаг тутам 20 минутаас доошгүй хугацаагаар түр зогсон, 24 цаг тутамд зөгийг нислэгт гарган, амрааж тээвэрлэнэ.

3.3.6. Техникийн шаардлага хангасан тээврийн хэрэгслээр зөгийг тээвэрлэхдээ зөгийчин дагалдах ба тэвшин дээр хүн суулгаж болохгүй.

3.3.7. Зөгийг 1 цагаас доошгүй хугацаанд тэвшин дээр хөдөлгөөнгүй байлгаж, тайвшруулсны дараа болгоомжтой буулгана.

3.3.8. Зөгийг ачих, буулгах ажлыг хамгаалах хувцастай гүйцэтгэх ба энэ үеэр гадны хүнийг байлгахгүй.

3.3.9. Зөгийг тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл нь засмал замд 60 км/цаг, орон нутгийн замд 20 км/цагаас хэтрэхгүй хурдтайгаар донсолгоог гаргаж, огцом эргэлт хийхгүйгээр зөөлөн явна.

3.4. Зөгийн бэлчээрт тавигдах шаардлага

3.4.1. Зөгийн бэлчээрийг сонгохдоо сүргийн тэжээлд хүрэлцэхүйц хэмжээний балт, тоост ургамал, усны эх үүсвэртэй байх, араатан амьтны халдлага, байгалийн аюулт үзэгдлээс хамгаалагдах нөхцөлийг харгалзана.

3.4.2. Зөгийн суурийг хүн амын суурьшлаас 400 м-ээс хол байрлуулж, анхааруулга тавина. Тухайн талбайн өмчлөгч, эзэмшигчид заавал мэдэгдэнэ.

3.4.3. Зөгийн суурийг чихэрлэг хүнсний үйлдвэртэй ойр байрлуулж болохгүй

3.4.4. Зөгийг бэлчээрт байршуулахдаа зөгийчний нэр, хаяг, утасны дугаарыг үлдээнэ.

3.5. Галын аюулгүй байдалд тавигдах шаардлага

3.5.1. Зөгийн аж ахуй нь учирч болзошгүй гал түймрийн аюулаас зөгийчид, зөгий болон бэлчээрийг хамгаалах ажлыг Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-ийн дагуу зохион байгуулна.

3.5.2. Зөгийчин нь галын аюулаас урьдчилан сэргийлэх, аюулын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх ойлголт, зааварчилга авсан байна.

3.5.3. Гал унтраах үүргэвч, галын хор, 9 л-ээс багагүй устай сав, төмөр хүрз, галын тармуурыг утуурын ойролцоо байрлуулна.

3.5.4. Утуурыг асаахдаа бензин, керосин, дизелийн түлш хэрэглэхийг хориглоно.

3.5.5. Утуурыг ашиглах явцад доод нүхээр нь галын оч хаяж байгаа эсэхийг шалгах ба оч хаях тохиолдолд утаа үүсгэж буй материалыг чийглэнэ. Аюулгүй байдлын үүднээс утуурыг ашигласны дараах үнс, нурамны гал бүрэн унтарсныг шалгана.

3.5.6. Галын ослын үед тухайн газрын хаяг, байршил, нөхцөл байдлын талаар аж ахуйн удирдлага, гал унтраах албанд мэдэгдэнэ.

3.5.7. Галд өртсөн зөгийг шууд устгана.

3.6. Зөгийчний хамгаалах хэрэгсэлд тавигдах шаардлага

3.6.1. Зөгийчний хамгаалах хэрэгсэл нь зориулалтын малгай, ажлын хувцас, бээлий, ханцуйвч, гутлаас бүрдэнэ.

3.6.2. Ажлын хувцасны техникийн шаардлага нь MNS ISO13688:2000 стандартад нийцсэн, өмдний шуумаг, гарны бугуйн хэсэг нь резинтэй, цагаан, цайвар шар, ногоон өнгөтэй хамгаалах хувцас хэрэглэнэ. Улаан, хар өнгийн болон үслэг, ноосон хувцас өмсөхийг хориглоно.

3.6.3. Малгай нь нүүр, толгойг зөгийн хатгалт, нарны хурц гэрлээс хамгаалах хар тортой, агаар сайн нэвтрэх даавуун материалаар хийгдсэн байна. Хар бараан өнгийн эсгий малгай, зөөлөн материалаар хийсэн малгай хэрэглэхийг хориглоно.

3.6.4.Бээлий нь резин, илгэн байх ба чөлөөтэй хөдөлж болохуйц тохой хүртэл хэмжээтэй, ханцуйвчтай, тохойн хэсэгтээ резинэн бэхэлгээтэй байна. Гялгар гадаргуутай урт бээлий, ханцуйвч хэрэглэнэ.

3.6.5.Түрийтэй, түрий хэсгээр бариу гутал, усны гутал болон шагай хамгаалах зузаан оймс, даавуу, нягт материалаар хийсэн нэмэлт түрий өмсөнө.

3.7. Зөгийчний ажил, амралтын горим

3.7.1.Зөгийчин нь хөдөлмөрийн дотоод журамд заасан ажлын цагийн горимоор ажиллах бөгөөд илүү цагийг Засгийн газрын 1999 оны 122 дугаар тогтоолоор баталсан “Ажлын цагийг нэгтгэн бодох журам”-ын журмын дагуу тооцно. Ажлын цагийг нэгтгэн бодож тооцох асуудлыг хөдөлмөрийн дотоод журамд тусгана.

3.7.2.Үйлдвэрлэлийн онцлогтой уялдан оргил ачааллын үед зөгийчин нь уртасгасан цагаар ажиллаж болох бөгөөд ажлын өдрийн үргэлжлэх хугацаа 12 цагаас илүүгүй байна.

3.7.3.Ажлын цагийг нэгтгэн бодох журмыг мөрдөж байгаа тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажилласан зөгийчнийг нөхөн амруулаагүй бол Хөдөлмөрийн тухай хуулийн 52, 53 дугаар зүйлд зааснаар цалин хөлсийг олгоно.

3.7.4.Хөдөлмөрийн тухай хуулийн 70.2-т зааснаас хэтрүүлэн ажилласан ажлын цагийг оргил ачааллын бус үед зөгийчнийг нөхөн амрах, ачаалал багатай үед ажлын өдрийн үргэлжлэлийг богиносгох, долоо хоногийн ажлын өдрийн тоог цөөрүүлэх, ээлжийн амралт дээр нь нэмэгдэл амралт олгох, сул зогсолт гарвал өмнөх хугацаанд хэтрүүлэн ажилласан цагт нь тооцож нөхөн амрах замаар зохицуулна.

3.7.5.Амралт, хоолны завсарлага эхлэх, дуусах цагийг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна.

Дөрөв. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаарх ажил олгогч болон зөгийчний эрх, үүрэг

4.1. Зөгийчний эрх, үүрэг

4.1.1.Зөгийчин дараах үүрэгтэй:

4.1.1.1.зөгийчин эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт заавал хамрагдах, харшилтай эсэхээ тодорхойлуулах;

4.1.1.2.зөгийчин нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эмнэлгийн анхан шатны тусламж, галын аюулгүй ажиллагаа, зөгийн арчилгаа маллагааны технологийг эзэмших;

4.1.1.3.хөдөлмөрийн дотоод журам, үйлдвэрлэлийн технологи, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар, аргачлалыг мөрдөх;

4.1.1.4.ажлын байрыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагын дагуу бэлтгэх, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгслийг зориулалт, зааврын дагуу хэрэглэх;

4.1.1.5.зөгийчин ажил олгогчийн заавраар ажиллах, ажил эхэлсэн, дууссан тухай болон осол, гэмтэл гарсан тухай бүр ажил олгогчид мэдээлэх;

4.1.1.6.хувийн ариун цэвэр сахих.

4.1.2.Зөгийчин дараах эрхтэй:

4.1.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байр, хамгаалах хэрэгсэл, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдах;

4.1.2.2.ажлын байрны нөхцөл, эрүүл мэндэд учирч болох эрсдэл, түүнчлэн үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн талаар бодит мэдээлэл авах;

4.1.2.3.хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажил, амралтын зохицуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбоотой зөрчлийг арилгахыг ажил олгогчоос шаардах;

- 4.1.2.4.ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийлгүүлэх;
- 4.1.2.5.аж ахуйн нэгжийн дотоодын хяналтад оролцох;
- 4.1.2.6.хуульд заасан бусад эрх.

4.1.3.Зөгийчинд дараах зүйлсийг хориглоно:

4.1.3.1.ажлын байранд архи, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх;

4.1.3.2.үзлэгийн үед тамхи татах;

4.1.3.3.зөгийтэй ажиллахдаа гадил жимс, сонгино, сармис идэх, үнэртэн, энгэсэг хэрэглэх, гялгар бөгж, гоёл чимэглэл зүүх;

4.1.3.4.хамгаалах хэрэгслийг үйлдвэрлэлийн бүсээс гаргах;

4.1.3.5.зөгийн арчилгаа, маллагааны технологи зөрчих.

4.2. Ажил олгогчийн эрх, үүрэг

4.2.1.Ажил олгогч дараах үүрэгтэй:

4.2.1.1.зөгийчнийг Эрүүл мэндийн сайдын 2014 оны 340 дүгээр тушаалаар баталсан “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам”-ын дагуу эрүүл мэндийн үзлэгт хамруулах;

4.2.1.2.үйлдвэрлэлийн онцлогт нийцсэн дүрэм, заавар баталж, мөрдүүлэх;

4.2.1.3.үйлдвэрлэлийн зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах;

4.2.1.4.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 тоот тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, шалгалт авах журам”-ын дагуу сургалтад хамрагдаж, шаардлагатай мэдлэгийг эзэмших, зөгийчнийг жилд 2-оос доошгүй удаа сургаж, мэргэшүүлэх;

4.2.1.5.ослын үед үйл ажиллагааг яаралтай зогсоож, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах, ослыг Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу бүртгэж, мэдээлэх, осолд өртсөн зөгийчнийг өөрийн зардлаар эмнэлэгт хүргэх, шаардлагатай үзлэг шинжилгээний зардлыг хариуцах;

4.2.1.6.ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийлгэх;

4.2.1.7.зөгийчнийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байр, хамгаалах хэрэгсэл, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах;

4.2.1.8.хэт халуун буюу хүйтэн, задгай газар, халаалтгүй байранд ажиллаж байгаа зөгийчнийг ахуйн байраар хангах.

4.2.2.Ажил олгогч дараах эрхтэй:

4.2.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэхэд төсөвлөгдсөн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах;

4.2.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, зааврыг зөрчсөн зөгийчинд Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай болон холбогдох бусад хууль, аж ахуйн нэгжийн дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэх;

4.2.2.3.зөгийчний хөдөлмөрийн дотоод журамд тусгагдаагүй асуудлаар тавьж буй шаардлагыг хүлээн авахаас татгалзах;

4.2.2.4.хамгаалах хэрэгсэлгүй зөгийчнийг зөгийн суурьт нэвтрүүлэхгүй байх;

4.2.2.5.зааварчилга, сургалтад хамрагдаагүй, шалгалт өгөөгүй зөгийчнөөр ажил, үүрэг гүйцэтгүүлэхгүй байх.

4.2.3.Ажил олгогчид дараах зүйлсийг хориглоно:

4.2.3.1.үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг нуун дарагдуулах;

4.2.3.2.зөгийчнөөр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал хариуцуулах;

4.2.3.3.зөгийчнөөр аюулгүй ажиллагааны заавар зөрчсөн ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг шаардах;

4.2.3.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэхэд төсөвлөгдсөн хөрөнгийг зориулалтын бусаар захиран зарцуулах.

Тав. Хяналт

5.1.Зөгийн аж ахуй нь Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 тоот тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив”-ын дагуу 20-иос дээш зөгийчинтэй бол хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөл байгуулах ба уг хэмжээнд хүрэхгүй тохиолдолд чиг үүргийг мэргэшсэн байгууллага, ажилтнаар гэрээгээр гүйцэтгүүлнэ.

5.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих төрийн захиргааны хяналтыг бүх шатны Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллага, алба, улсын байцаагч, аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан эрх хэмжээний хүрээнд тавина.

5.3.Зөгийчний ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах болон төрийн бус байгууллага олон нийтийн хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.3.1.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын талаар үнэн зөв мэдээлэл авах;

5.3.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомжийн зөрчлийг арилгах шаардлагыг ажил олгогчид тавих;

5.3.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар үүссэн маргааныг хэлэлцэх, шийдвэрлэхэд оролцох;

5.3.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, хөдөлмөрийн нөхцөлийг дордуулсан, зөгийчний эрүүл мэнд, амь насыг хамгаалах үүргээ биелүүлэхгүй байгаа албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх саналаа холбогдох байгууллагад тавих.

5.4.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн үе шат, ажлын байр бүрт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, нийтлэг шаардлагын хэрэгжилт, ажлын байрны эрсдэлийн үнэлгээний дагуу авагдсан арга хэмжээний биелэлтэд дотоодын хяналт тавина.

5.5.Ажил олгогч нь дотоодын хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах үүрэгтэй.

Зургаа. Хариуцлага

6.1.Энэ дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн зөгийчин, ажил олгогчид Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.